

Х№1, Д-1, ХН-109

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ОЛОН ХОТ БА ХОТЫН ЭРХТЭЙ СУУРИН ЗЭРЭГ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРУУДЫН ДАГАЖ ЯВАХ ДҮРЭМ

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Энэхүү дүрмийг тус улсын бүх хотууд ба суурин газрууд засгийн газраас баталж зарласан өдрөөс эхлэн нийтээр журамлан дагаж гүйцэтгүүлвээс зохимуй.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Аливаа хот ба суурин газруудын хэрэг ба аж ахуйг эрхлэн гүйцэтгүүлэхийн учир тус тус захиргааны газар байгуулмуй.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Энэхүү захиргааны газруудын эрхлэн гүйцэтгүүлвээс зохих зүйлүүд нь

1. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын засгийн газрын зэрэг олон албан яамны газруудын тогтоолыг улмаар явуулан гүйцэтгэмүй.
2. Харьяат хотын элдэв боловсруулах ба аж ахуйг сайжруулах аргыг сүвэгчилмүй.
3. Хотын буй ба мөн хотын өөрчилвөөс зохих зүйлийн зургийг зуруулж мөн зургийн ёсоор хотыг сайнаар гүйцэтгүүлэх зэрэг барилгыг харшгүйгээр бариулахыг санаа тавьж орон байшин зэргийг зүй зохистой байгуулахыг хянамуй.
4. Харьяат хот доторх аливаа гудамж их чөлөө морьтой явган хүмүүсийн явах зам, цэцэрлэгийн хүрээлэн, гол усны эрэг, усны галд онгоцны буух газар ба мөн хөөрөг, усаар гатлан нэвтрэх зүйл, худаг шуудуу мал услах зэрэг газрыг сайнаар бэлтгэж зүй зохистойгоор суулгахыг хичээмүй.
5. Хот дотор хэрэгсэх сайн гэрлийг сайнаар байгуулж зүй зохистойгоор агуулах, тус хотын хэрэгсэх ус мал нядлах газар мөн зүйлд холбогдох зэргийн олон ардад тус бүхий үйлдвэрийг сайнаар байгуулж зүй зохистойгоор агуулмуй.
6. Харьяат хот дотор галын зэргийн аюулыг сэргийлэх аргыг сүвэгчлэх ба галын аюулыг сэргийлэх албаны усан хөөргийн орон байгуулахаас гадна мөн аюулыг сэргийлэхээр энгийн хүмүүсийн дуртай байгуулсан газруудын явуулан бүхий ажлыг хянах жич пийшингийн яндан зэргийг арилгах цэвэрлэх тухайн товчлон эрхлэх газрыг байгуулах явдлыг гүйцэтгэмүй.
7. Хот дотор аливаа үг хэл харилцах телефон зэргийн боловсронгуй зүйлүүдийг бэлтгэн зүй зохистой агуулахаас гадна тээх нэвтрүүлэх явдлыг хянаж байваас зохимуй.
8. Харьяат хотын аливаа хог бүртгийг ариутгах цэвэрлэх явдлыг гүйцэтгэж хог шороо зэрэг зүйлүүдийг зайлуулан асгах газруудыг заан олгомуй.
9. Эмнэлгийн газар ба эмийн пүүс хүний бие угаах халуун усны газрууд байгуулах зэргээр олон ардыг өвчин эмгэгээс хамгаалах ариун цэвэр байлгах явдлыг гүйцэтгэмүй.
10. Харьяат хот дотор аливаа хоол хүнсний зүйлийг тэгшитгэн олон хүний хооллуулах ба өнчин ба ядуу хоосон хүүхдийг тэтгэн хүмүүжүүлэх зэргийн газрууд байгуулмуй.
11. Харьяат хотын дотор аливаа идэх хоол зэргийн чухал хэрэгсэх зүйл ба суух орныг дутагдуулахгүй ба үнийг үлэмж болгохгүйг хичээж хялбар хөлс орон байшин ба гаднаас ирэгчдийн буудлын газар жич олон ардын цайлах хооллох жич талх мах сүү түлш зэргийг худалдуулах газрууд бэлтгэмүй.
12. Зах зээлийн газар дэлгүүрүүдийг байгуулах ба бараа агуулах газар хүйтэн зорь зэргийг бэлтгэх бөгөөд худалдааг зүй зохистой үйлдэж буй үгүй ба аливаа хэмжүүр хэрэгссэн эссэнг хянаваас зохимуй.

13. Хот доторх тоо бүртгэх явдлыг судлан гүйцэтгэвээс зохимуй
14. Хотын хөрөнгө болгон хураах татвар ба эв ээлжний алба үүрэг зэргийг эрхэлмүй.
15. Хотын харьяат хөрөнгө хогшлыг эрхэлмүй.
16. Аливаа хүн ба олон нь аюулаас хамгаалах бүсийн журмыг сахих аргыг хууль дүрмийн ёсоор гүйцэтгэхээс гадна цагдан сэргийлэх хэргийг дүрмийн ёсоор эрхэлмүй.
17. Тусгай хууль дүрмийн ёсоор эрхлүүлсэн хэргүүдийг гүйцэтгэмүй.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын захиргааны эрх нь тус хотын дэвсгэр газраас үл хэтрүүлэн харьяат хэргүүдийг өөр эрхлэн тогтоомуй.

ТАВДУГААР ЗҮЙЛ. Хотын захиргааны газар нь иргэний нийтийн хууль дүрэм ба энэхүү дүрмийн ёсоор харьяат хотын нэрээр аливаа хогшил хөрөнгө худалдан авах өгөх гэр бичиг тогтоох авах зүйлийг нэхэмжлэх аливаа хөрөнгө хогшлын тухай зарга шийтгэх газар, албаны газрын ёсоор хариуцах зэргийн эрхтэй буй.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Хотын хүмүүст тогтоосон хууль дүрмийн ёсоор зохих газруудаас ногдсон татвараас өөр зүйлийн татварыг ногдуулж үл болмуй.

ДОЛООДУГААР ЗҮЙЛ. Хотын захиргааны газар аливаа явуулсан хэргийг дотоод явдлын яамнаа хянуулж байваас зохимуй.

НАЙМДУГААР ЗҮЙЛ. Аливаа хотын захиргаа нь өөр өөрийн нэрийн үсэг бүхий тамгатай байваас зохимуй.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын захиргааны газрын орон тоо эрх мэдэл хэрэг явуулах тухай явдлыг гүйцэтгэх хэлтэс салаад хотыг эрхлэх газар болмуй.

1. Хотын хурал
2. Хотын захиргааны хэрэг эрхлэх газар ба түүнд захирагдах газрууд бүгд оролцвоос зохимуй.

ХОТЫН ХУРЛЫН ЯВДЛЫН ТУХАЙ

АРАВДУГААР ЗҮЙЛ. Хотын хурал нь хотын ба мөн хотод олгосон газруудын эзэн болох бөгөөд мөнхүү газар суугаа хүмүүсийг язгуурын захиргаанаа шашин үндсээр үл ялгаварлан хамтатгаж тус захиргааны хэрэгт оролцуулмуй.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын хурлыг харьяат хотын жинхэнэ ардуудаас сонгогдсон тогтсон тооны гишүүдээр байгуулваас зохимуй. Үүнд тайлбарлах нь, Монгол Ард Улсын олон хот доторх хүн амын тоог тодорхой бүртгэж мэдээ хураах хүртэл Улаанбаатар хотноо дөчин таван төлөөлөгчдийг сонгох бөгөөд бус хотуудад арван таван төлөөлөгчдөөс дорогш бус сонгомуй. Үүнд хот бүрийн бүгд төлөөлөгч нарын гурван хувийн нэг хувьд даацуулан орлогч нарыг сонговоос зохимуй.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Хотын зөвлөлд үндсэн хуулийн гучин тавдугаар зүйлд дурдсан хүмүүсээс бусад мөн өдөр арван найман нас хүрсэн ба мөн наснаас дээш эр эм ялгалгүй сонгох сонгогдох эрхтэй буй.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Хотын хурлын төлөөлөгч нарыг нэгэн жилийн хугацаагаар сонговоос зохимуй.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын төлөөлөгч нарын хурлыг хотын захиргааны газрын товчоо ба хотын даргаас эрхлэн зарлаж хуралдуулмуй.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ. Хэрэв хотын хурлын төлөөлөгчид сонгогдсон хэн ч атугай сонгогдсон хугацааны инару ямар нэгэн шалтгаанаар эрхээ алдах буюу гишүүн тушаалыг түлхэх ахул бүрмөсөн халагдсанаар үзэж хугацаа төгсөх хүртэл хотын хурлын гишүүдийн зохих дансны дараалсан орлогчоор албан гүйцэтгүүлэх бөгөөд эрхээ алдсан гишүүн нь хотын хурлын төлөөлөгчдийн данснаас бүрмөсөн хасагдваас зохимуй.

АРВАН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Хотын төлөөлөгчдийн хурлыг сар бүрт нэг удаагаас цөөнгүй хуралдуулваас зохимуй. Үүнд тайлбарлах нь хотын захиргааны хэрэг эрхлэх газрын товчоо буюу хотын хурлын гишүүдийн гурван хувийн нэгний мэдүүлснээр мөн хотын гишүүдийн онц хурал хуралдуулж болмуй.

АРВАН ДОЛООДУГААР ЗҮЙЛ. Хотын төлөөлөгчдийн хуралд хотын хурлын төлөөлөгч нар бус ч атугай хотын захиргааны хэрэг эрхлэх газрын хэлтсүүдийн эрхэлсэн түшмэл нар суулцмуй. Үүнд тайлбарлах нь, орлогч нар ба бусад хүмүүс хотын хурлын гишүүн бус ахул гагцхүү зөвлөх эрхтэйгээр суулцваас зохимуй.

ХОТЫН ХУРЛААР ТОГТООН ШИЙТГЭВЭЭС ЗОХИХ ХЭРГҮҮД НЬ

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ. Хотын хурал нь ерөнхийлөн захирах ба хотын захиргааны газрын аливаа явдлыг гүйцэтгэх хэлтэс салаа зэргийг хянах онгодсон хэргийг шийтгэн тогтоох зэрэг зүйлийг гүйцэтгэмүй.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын хурлын эрх нь

1. Энэхүү дүрмийн дотор дурдсан тушаалын хүмүүсийг сонгомуй
2. Хотын захиргааны газрын хэрэг гүйцэтгэх аливаа газруудад хэрэг явуулах заавар олгомуй.
3. Орлого зарлагын төсөвлөсөн дансыг тогтоомуй
4. Хууль дүрмийн ёсоор тогтсон татварын хэмжээг тогтоомуй
5. Хотын татварт хурааваас зохих дутагдуулсан мөнгөнөөс үнэхээрийн хураалгаж үл чадагчдын ногдлыг хэрэгсэхгүй болгомуй.
6. Хотын харьяат мөнгө ба бусад хөрөнгө хогшлын захиргааны газрын мэдэлд бүхий олон ард улсад тус бүхий эмнэлэг зэргийн газруудыг эрхлэн гүйцэтгэх дүрэм заавар тогтоомуй.
7. Талх мах жич олны хэрэгсэх хөлсний морь, уурын тэрэг зэргийн үнэ хөлсийг тогтоомуй.
8. Хотын захиргааны газарт орлого болох аливаа онгоц мал нядлах газар худаг аливаа газар ба хүнд бараа агуулахаар олгосон хэсэг газруудын түрээсний хэмжээг тогтоомуй
9. Харьяат хотын нэрээр мөнгө зээлдэн авах өгөх тухайн гэр бичиг байгуулах явдлыг хэлэлцмүй.
10. Харьяат хотын туст тусламж болгон өгсөн зүйлийг хүлээн авах явдлыг гүйцэтгэмүй.
11. Аливаа дагаж гүйцэтгэх тушаал зохион зарламуй.
12. Хотын зураг зохиох ба өөрчлөх зүйлийг гүйцэтгэмүй.
13. Хотын захиргааны хэрэг эрхлэх газрын албан шийтгэн явуулсан хэрэг ба тайлан дансыг хянахаас гадна тус газрыг заалдан мэдүүлсэн хэргийг байцаан шийтгэмүй.

14. Хотын захиргааны хэрэг эрхлэх газрын албан үүргийг хүлээсэн хүмүүс тухайн хэргүүдээ будлиантуулан осолдуулахад хүрүүлэхгүйг хянах
15. Хотын захиргааны хэрэг эрхлэх газарт хууль дүрмийн ёсоор олгуулсан газраас үл хэтрүүлэн худалдаа үйлдэж бүхий явдлыг хянаж баймуй.
16. Хотын хэргүүдийн тухайг засгийн газар мэдүүлэх зүйлийг гүйцэтгэмүй.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ. Хотын хурал нь өөрсдийн хуралдах цагийг урьд тогтоохууд нэг жилд арван хоёроос цөөнгүй төлөвмүй. Хотын захиргааны газрын өнгөрсөн жилийн орлого зарлагын төсөвлөсөн дансыг хэрхэн гүйцэтгэсэн зэргийн тайланг хэлэлцэх хурлыг гурван сар ирэх жилийн орлого зарлагын дансыг хэлэлцэх хурлыг найман сараас тус тус хэтрүүлэлгүй хуралдуулмуй.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын хурлыг аль сарын хэдний хэдэн цагт хуралдах явдлыг хотын захиргааны газрын товчооны тушааснаар хуудсаар хурлын гишүүдэд урьдаар захируулахууд хэлэлцэх зүйлүүдийг тодорхойлж хамт хүргүүлмүй.

ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Хотын онц хурлыг хотын захиргааны газрын дарга буюу товчоо эс бөгөөс хотын төлөөлөгчдийн гурван хувийн нэг хувиас дутахгүй төлөөлөгчид хүсэх аваас хуралдуулмуй.

ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Хотын төлөөлөгчдийн хурлаас тус хуралд хэлэлцэх төвөг бүхий хэргүүдийг өөрийн гишүүд буюу мөн гишүүдээс томилогдсон тусгай комиссод төлөвлөн хэлэлцүүлж болох тул мөн хурлаас хэрэгсэхийг үзэж хугацаа тогтоомуй. Хотын захиргааны газрын төсөвлөсөн дансыг хэрхэн гүйцэтгэсэн тайлан хянан хэлэлцэхууд хотын хурлын төлөөлөгч нарын байцаах комисс эрхбиш сонгомуй.

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын хурал нь хурлын тогтоолын ёсоор тус хурлын гишүүн бус хүмүүсийг хэрэглэж хурал дээрээ саналыг илтгүүлэх учир тохиолдвоос урин ирүүлэх эрхтэй байваас зохимуй.

ХОРИН ТАВДУГААР ЗҮЙЛ. Хотын хурал нь бүгд төлөөлөгчдийн хагас хувиас дорогш бус нь цугларваас хүчин төгөлдөр болгон хэргүүдээ зөвлөн хэлэлцвээс зохимуй.

ХОРИН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Хотын хурал нь аливаа хэргийг олонхын саналаар шийтгэх бөгөөд хэрэв саналаар болохоос гадна төлөөлөгчид бүр нэг хүний эрхтэй бөгөөд өөрийн хэргийг бусдад шилжүүлж үл болмуй.

ХОРИН ДОЛООДУГААР ЗҮЙЛ. Хотын захиргааны хэрэг эрхлэх газрын дарга гишүүд ба орлогч нарыг хотын хурал нууцаар сонгомуй. Албан суугчдыг шийтгүүлэх эсэх цалин ба мөнгөн тусламж олгох эсэх явдлыг тогтоохууд мөн нууцаар гүйцэтгүүлж бусад зүйлийг хотын хурлаас зохихыг үзэж ялган хянаж тогтоомуй.

ХОРИН НАЙМДУГААР ЗҮЙЛ. Аливаа хэлэлцэн тогтоосон зүйлийн тогтоол бичиж дарга мөн хуралд байсан гишүүд гарын үсэг зурж нарийн бичгийн дарга үсэг зарж баталмуй. Хотын хурлын тогтоолыг бичих нь гагцхүү нарийн бичгийн даргын үүрэг байваас зохимуй.

ХОРИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын хурлын тогтоолын хуулга ба тусгай хавсарга зүйлүүд хамт хотын захиргааны даргаас тухай бүрт дотоод явдлын яамнаа хүргүүлвээс зохимуй.

ГУЧДУГААР ЗҮЙЛ. Хотын хурал хэлэлцсэн нь төлөөлөгчдийн баталсан даруй хүчин төгөлдөр болох боловч

1. Харьяат хотын өөрийн нэрээр мөнгө зээлдэх даалгах батлах явдал нь урьд зээлдсэн баталсан мөнгөний хамт нэг жилийн төсөвлөсөн орлогын дүнгээс хэтрэх
2. Энгийн хүмүүстэй гэр бичиг баталж тус хотын үйлдвэр байгуулуулан ашиглуулах тухайд зохих яамуудтай хэлэлцүүлэн дотоод явдлын яамнаа батлуулаас зохимуй.

ГУЧИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Хэрэв дотоод явдлын яамны сайдаас гүйцэтгүүлэсэн хотын хурлын тогтоолыг баталж чадахгүй ахул уг тогтоолгүй буюу болох тул мөн сайдаас уг тогтоолыг ямар учраар үл баталсанг хотын хуралд мэдэгдмүй. Хотын хурлаас сайдын үл баталсан учир нийлэлцэхгүй хэмээхүл засгийн газар мэдүүлж болмуй.

ГУЧИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Хэрэв хотын хуралд зохих тооны гишүүд ирэхгүй ахул хурлыг хойшилж хотын даргаас дахин хурал зарламуй. Гагцхүү дараагийн хотыг анх хуралдуулах хэмээсэн өдрөөс долоон өдрөөс инагш хуралдуулж үл болмуй. Дараагийн хуралд хэчнээн гишүүд хуралдсан боловч болох бөгөөд учрыг гишүүдэд хурал зарлахуйд мэдэгдвээс зохимуй.

ХОТЫН ХУРЛЫН ШИЙТГЭСЭН ХЭРГҮҮДИЙГ ГҮЙЦЭТГЭХ ГАЗРУУДЫН ТУХАЙ

ГУЧИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Хотын хурал нь өөрсдийн дотроос хотын захиргааны хэрэг эрхлэх газрыг байгуулахуйд, Улаанбаатар хотноо долоон гишүүдийг бус хотуудад тав таван гишүүдийг сонгомуй. Эдгээр гишүүд нь өөр өөрийн дотроос гурван хүнээс илүү хүмүүсийг томилон товчоо болгож дарга даргын орлогч ба нарийн бичгийн дарга сонгомуй. Үүнд тайлбарлах нь, бага хотуудад хотын захиргааны хэрэг эрхлэх газрын албыг дотоод явдлын яамны сайдын зөвшөөрлөөр гагцхүү даргад ноогдуулж хотын хурлаар орлогчийг сонгуулан томилмуй.

ГУЧИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. Хэрэв хотын захиргааны хэрэг эрхлэх газрын даргад өвчин эрхийн онц учир тохиолдох буюу өөр хууль дүрмийн ёсоор тусгай үүрэг оногдуулсан зэрэг учир өөрийн албыг түр гүйцэтгэж чадахгүй ахул даргын албыг түүний орлогч \сүүлийн нэг мөр гаргацгүй.\

ГУЧИН ТАВДУГААР ЗҮЙЛ. Хотын захирганы хэрэг эрхлэх газрууд

1. Ерөнхий хэлтэс
2. Ардыг сэхээрүүлэх хэлтэс
3. Ардын эрүүлийг сахих хэлтэс
4. Аж үйлдвэрийн хэлтэс. Энэхүү хэлтэсд санхүү ба аж ахуй, тоо бүртгэх салаа тогтоож болмуй.

ГУЧИН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Хотын захиргааны хэрэг эрхлэх газрын нийтийн хурлыг товчооноос сар бүрийн нэг удаагаас цөөнгүй зарлан хуралдуулж тус газрын товчооны ба хэлтсүүдийн илтгэл, хотын хуралд хэлэлцвээс зохих зүйлүүдийг хэлэлцвээс зохимуй. Үүнд тайлбарлах нь, хойшилж үл болох яаралтай онц учир тохиолдвоос ахул товчооноос онц хурал хуралдуулмуй.

ГУЧИН ДОЛООДУГААР ЗҮЙЛ. Хотын захиргааны хэргийг эрхлэх газрын тэргүүлэгчдээс харьяат засгийн газрын олон яам ба бусад газартай харилцахаас гадна тус газрын харьяат хэлтэс сэлбаруудын гүйцэтгэх хэргүүд ба жич хотын хурлуудын завсар тус захиргааны бүхий хэргүүдийг удирдан явуулмуй.

ГУЧИН НАЙМДУГААР ЗҮЙЛ. Энэхүү дүрмийн ба бусад хууль дүрмийн ёсоор тус хотын аж үйлдвэрийн бүх хэргийг шууд эрхлэн явуулах явдлыг тус хотын захиргааны хэрэг эрхлэх газрын дарга мөн захиргааны газар ба түүний хэргийг гүйцэтгэгчдэд даалган эрхлүүлмүй. Басхүү тус хотын хурлын тогтоолын ёсоор хотын хөрөнгө хогшил ба эдлэл хэрэгслийг тус захиргааны хэргийг эрхлэх газраас бэлтгэн авч байгуулваас зохихын дээр хотын бүх хэргүүдийг ба аж ахуйн явдлыг эрхлэн явуулах сайжруулан боловсруулах тухай арга сүвэгчлэхийг эрмэлзвээс зохих бөгөөд мөн хотын хуралд хэрэглэгдэх элдэв мэдээ хурааж тухайд тогтоосон дагаж гүйцэтгэх хотын төсөвлөсөн дансыг зохион үйлдэх уг тогтоосон дүрэм ба хотын захиргааны хурлын тогтоолуудыг баримтлан хотын доторх татварыг татаж хураах ба зохисыг үрж зарцуулах тус захирагдах албаны хүмүүс ба мөн газрын эрхлэн явуулж бүхий хэргүүдийн бүртгэлийн тайлан дансны тухай заавар ба хугацааг хотын хурлын зөвшөөрлөөр тогтоохоос гадна мөнхүү бүртгэлийн тайлан дансуудыг хянан үзэж тус хотын хуралд өргөн мэдүүлвээс зохих зүйлүүд нь

1. Тус газрын хэрхэн гүйцэтгэн явуулсан хэргүүдийн тухай
2. Хот санхүүгийн элдэв орлого зарлагын тухай
3. Харьяат хот газруудын байр байдал ба аливаа барилга эд хүрсний тухай болмуй.

ГУЧИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын захиргааны хэрэг эрхлэх газрын явуулах албан хэрэгт оролцох зүйлүүд нь тус хотын харьяат газрын дэвсгэр дээр аливаа байгуулах энгийн ард түмний орон байшингийн маяг зургийг хянаж батлах ба шинэтгэн байгуулах сэлбэж засуулах тухайд зөвшөөрлийг олгомуй. Үүнд тайлбарлах нь Улаанбаатар хотноо аливаа орон байшин шинээр ба нэмэн байгуулах тухай маяг суурь зэргийг хянан үзэхүйд тус хотын зөвлөх хурлаар мөнхүү орон байшин байгуулах тухай боловсронгуй техник хүнийг урин ирүүлж мөн зөвлөх эрхтэйгээр суулгаваас зохимуй.

ДӨЧДҮГЭЭР ЗҮЙЛ. Тус хотын дотор аливаа эд оруулах завод ба аж үйлдвэрийн газруудыг байгуулахад хэрэв мөн этгээдээс харшлах зүйлгүй зэргийн газар буй аваас тухайд тус хотын захиргааны хэрэг эрхлэх газраас үл татгалзан зөвшөөрлийг олгох эрх буй боловч эл дурдсан эд боловсруулах завод ба аж үйлдвэрийн газар чухам байгуулж болох эмхүү тус хотын захиргааны хэрэг эрхлэх газар энэхүү зүйлийн ёсоор дангаар мэдэхгүй учир мөнхүү завод зэргийн газруудын нэрсийг дотоод явдлын яамнаас аж ахуйн явдлын яамны зөвшөөрлөөр тогтоон зарламуй.

ДӨЧИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын захиргааны газрын хурлаар зөвлөж шийтгэх хэргүүдийг олонхын саналаар шийтгэж гүйцэтгэх бөгөөд мөн хуралдах гишүүдийн санал тэгш хуваагдахад хүрвээс даргын санал нийлцсэнээр болгон дагаж шийтгэвээс зохимуй. Хэрэв хотын захиргааны газрын эрхлэх хэргээс тус хурал зарлахыг хүлээж үл болох чухал яаралтай хэрэг тохиолдвоос тус газрын даргаас гүйцэтгэн шийтгээд хэрхэн шийтгэсэн учрыг тус хотын захиргааны газар дараагийн хуралд тодорхойлон мэдэгдвээс зохимуй.

ДӨЧИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. Хотын захиргааны ба түүний харьяат газруудын хэрхэн явуулан бүхий хэргүүдийг ерөнхийлөн хянан байцааж гүйцэтгүүлэхээс гадна эрхийн дотор буй хэрэглэгдэх элдэв зүйлийн мэдээ хураах тухай захирах тушаах хэргүүдийг тус газрын даргаас эрхлэн гүйцэтгэвээс зохимуй.

ДӨЧИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. Хотын захиргааны харьяат газрын явуулан буй хэргүүдийг дотоод явдлын яамны сайд ба улсын хянан байцаах газраас тусгай томилогдсон хүмүүс салган байцааж үзэхүйд хууль дүрэмд үл нийлэлцэх хэргүүдийг үйлдэж будлиан бүхий хэргүүдийг дүрэмд нийлүүлэн гүйцэтгэж явуулахаар тогтоолговоос зохимуй. Хэрэв шалган

байцаахуйд тушаалын хүмүүсээс гэм эрүүд холбогдох албаны хэргийн сэдэв гарваас мөнхүү хэргийг шүүх таслах газар шилжүүлэн хүргүүлж шийтгүүлвээс зохимуй.

ДӨЧИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын доторх хогшил хөрөнгө ба барилгуудын тухай эрхлэн явуулах тэр мэт ногсон /ноогдсон/ үүргийг гүйцэтгэхийн тул тус тус тусгай бэлтгэсэн боловсронгуй ухаан хэрэглэгдэх учир хотын хурлын гишүүн бус хүмүүсийг тус хотын захиргааны газраас урин ирүүлж болохоос гадна тус газрын албан үүргийг хааж бүхий хүмүүсийг томилох ба халах явдлыг хотын захиргааны газрын даргаас эрхлэн гүйцэтгэвээс зохимуй.

ДӨЧИН ТАВДУГААР ЗҮЙЛ. Албаны учир даалган худалдуулсан хогшил хөрөнгөний зүйлүүдээс хотын захиргааны газрын дарга мөн туслах тус газрын олон гишүүд ба бусад харьяат газруудын албан хаагчид нарын худалдан авах эрхгүй байваас зохимуй.

ХОТЫН ЗАХИРГААНЫ ГАЗРААС ТУС ХОТЫН ДЭВСГЭР ДЭЭР СУУГАА ГАДААД ДОТООДЫН ОЛНУУДАД ЭРХБИШ ДАГАЖ ГҮЙЦЭТГҮҮЛЭХЭЭР ГАРГАХ ТОГТООЛУУД ТУХАЙ

ДӨЧИН ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. Хотын хурлаас эрхбиш дагуулж гүйцэтгүүлэхээр гаргах тогтоолын зүйлүүдийг доор сийрүүлэн бичсэн нь:

1. Тус хотын доторх орон байшин ба гудамж зэрэг тогтоосон дүрэм журмыг дагаж байгуулуулах тухай
2. Аливаа эд боловсруулах завод фабрикийн зэргийн орон савыг байгуулж үл болох газрыг заан тогтоох тухай.
3. Энгийн хүмүүсийн орон байшин байгуулж суух газрын дэвсгэрийг хэсэг анги болгон ялган салгах ба барилга үйлдүүлэх тус хот харьяат тусгай анги дэвсгэрүүд дээр аливаа байгуулах орон байшингийн өндрийн хэмжээ ба мөн давхрын тоог тогтоох хүн суух байшингийн лоторх өндрийн ба цонхны хэмжээ тогтоох мөн байшингуудын гаднах маяг янз, тус хотын аль нэгэн анги дэвсгэр дээр орон байшингуудыг эрхбиш чулуугаар байгуулах нь зүйтэй хэмээн тогтоосон аваас мөнхүү дэвсгэр дээр бүхий хуучин модон орон байшингуудыг зөөлгөн зайлуулах буюу оронд мөн чулуугаар байгуулах хугацааг тогтоох гудамж ба зах зээлийн газар мод цэцэрлэг тариулах мөн гудамж явган зам бэлтгэх зэрэг явдал нь цөм хот дотор суугаа ардуудын үүрэг болмуй.
4. Галын аюулыг сөнөөх тухай байшингийн дээвэр ба пийшингийн янданг галын аюул болгохгүйгээр байгуулах мөн түүнийг сайнаах байгуулах ба цаг цагаар хнан үзүүлж байх галын аюулд осолтой зүйлүүдийг агуулах орон сав байгуулах газрыг заан онуулах, мөнхүү зүйлийг хэрхэн хадгалах зааварлах зэргээр галын аюулаас сэргийлэх олон хүмүүсийн цугларах газар галын аюул сөнөөх багаж хэрэгслүүдийг бэлтгэж мөнхүү галын аюулаас сэргийлэх галын аюулаас хүний хөрөнгийг хамгаалан авах ба мөн аюулыг сөнөөхийн тул шөнийн харуул манаа байгуулах гудамж ба хашааны хооронд харилцан явуулцах үүд хаалга гаргажбэлтгэх тухай.
5. Осол чанхны зэрэг цаг бусын аюулаас хүн, хөрөнгийг хэрэглэх ба хамгаалахын тухай
6. Тус хотын мэдэлд буй олны байгуулсан орон хэрэгслийг хуучин балар цагаас үлдсэн хөшөө цулуу ба онц төрлийн адгуусан амьтан ба мод ургацыг байлгахыг сэргийлэн сахих тухай
7. Гудамж зээл хөрөнгө явган зам цэцэрлэгийн хүрээлэн усны олом гол худаг ус ба мөн газар доор буй ус зэргийг бохир буртаггүй ариун цэвэр байгуулахыг эрхлэх тухай.

8. Харьяат хотын олон ардад хэрэглэгдэх цэвэр усыг хашаа байшин дотор татан авчруулах цорго бэлтгүүлэх ба мөн усыг хэрхэн хэрэглүүлэх аргыг зааварлах байшингийн дээврээс гоожих борооны ус урсах шуудуу цорго бэлтгүүлэх тухай
9. Харьяат хотын газар худалдаа наймаа үйлдэх газар орон сав байгуулах ариун цэврээр байлгах, мөн дотоодын байдал ба худалдаа үйлдэх цагийг тогтоох тухай
10. Нийгмээр хэрэглэх гэрэл ба ус татаж авчруулах газар байгуулах мөн түүнийг хэрхэн нэвтрүүлэх тухай
11. Аливаа морь ба уурын тэргүүдээр хүмүүс ба ачаа зэргийг тээн нэвтрүүлж ашиглах тухай
12. Гудамж ба гол усны гүүр ба онгоцоор нааш цааш явахууд саад боомт ба аюул осолгүй болгох тухай.
13. Харьяаны хаалган гудамжийг гэрлүүд ба шат хийгээд гудамжийг баас шээсний жорлон зэргийг бэлтгүүлэн тонилуулах тухай.
14. Олон ардын хуралдах газар амгалан ба журмыг сахиулах тухай
15. Аливаа халдвар бүхий өвчин эмгэгээс сэргийлэх ба мөн өвчнийг сөнөөн арилгах тухай.
16. Архи ууж тамхи татж согтуурах садар самуун явах гэмийг устгаж арилгах тухай
17. Ариун цэврийг сахиулж бохир буртгаас зүтгүүлэхийн учир аливаа аж үйлдвэрийн завод фабрикийн газар олон ардын хуралдан цэнгэлдэх газар бүжгийн газар аливаа сургууль ба эмнэлгийн газар, эмийн пүүсийг сүү боловсруулах газар, эмч нарын тасаг хүн суух байшингууд хөлсний суух орон гэр аливаа буудлын хашаа башин гэр ажил үйлдвэрчний суух орон байшин өнчин ба үгээгүй ядуу хүмүүсийн хоолгох гэр орон бие ба мах худалдуулах эсэх, хоол хүнс бэлтгэж худалдуулах боловсруулах хадгалах газар басхүү олон мал хаших хашаа сав байгуулах зэргийг цаг ямагт харгалзан үзэж ариун цэвэр байлгаваас зохих тухай.
18. Хашаа байшин цэвэрлэх учир элдэв угаалын усыг асгах нүх малтах баас шээсний жорлон бэлтгэх ба мөнхүү хог шороо зэргийн бохир буртгийг аваачиж хаях тусгай газрыг заан олгох тухай
19. Хортой адгуусан амьтан ба хорхой батгана зэргийг сөнөөн устгах арга сүвэгчлэх тухай
20. Газрын хөрс ба уурын хийг муудуулахгүй олон ардын хэрэглэх ус гаргах элдэв худаг байгуулах мөн хэрхэн эдлүүлэх тэр мэт болон уснаас хэрхэн хэрэгсэх тухай.
21. Аливаа худалдааны газар хүний идэх уух зүйлүүдийг цэвэр сайхан байлгах тухай
22. Аливаа хаягдал болох үлдэл ба эдийн үртэс зэргийг худалдан авах ба мөн худалдаж боловсруулах тухай
23. Аливаа адгуусан амьтанг нигүүлсэн үзэж хэмээвээс зохихын тулд сайнаар эдлэн хэрэглүүлэх тухай
24. Аливаа өгсөн мал адгуусны яс махыг аваачиж хаях буюу устгах тухай ба эс бөгөөс тэдгээр үхдэлийн яс махыг боловсруулан өөр зүйлд хэрэглүүлэх тухай
25. Аливаа худалдааны ба аж үйлдвэрийн газрыг нээх ба хаах цагийг тогтоож тус газруудад албан хааж бүхий аж үйлдвэрийн хүмүүсийг хүч үнэлэгчдийн дүрмийн ёсоор амруулах тухай.
26. Бага насны хүүхдийн биеийн тэжээлийг муудуулахгүй ба зан авирыг гажуудуулахгүй учир аж үйлдвэрийн худалдааны газар ба олны үймэлдэн хуралдах архи тамхи ууж цэнгэлдэх зэргийн газар хөлслөн авахуулж үл болох тухай

27. Олны идэх хоолны пүүс гаргуулах ба мөн түүнийг сайнаар байлгах тухай мөнхүү пүүсийг гаргуулж үл болох газрын ангийг заахаас гадна эдгээр хоолоо пүүсүүдэд амгалан байдал ба шударга байлгахыг харгалзах тухай
28. Тэргээр чирэх буюу үүрч худалдуулах дамын худалдаачин журамлан явах тухай
29. Сангийн жин ба жигнүүрт жигнэх аливаа хүнсний зүйл ба эд бараанаас хураах татварын үнийг тогтоох тухай
30. Олон ардын юуны урьд худалдан авах юмыг дутагдуулахгүй ба үнэ асар үлэмж болгохгүйн тухай ба мөн хоол хүнсний зүйлийг тогтоон худалдуулуулах зах зээлийн газраас гадуур дам худалдан авагчдыг цаазлан зогсоох тухай
31. Тэмдэг гарчин зэргийг хадуулж байгуулах тухай
32. Тогтоосон дүрэм завар баримтлан бусад зүйлүүдэд эрхбиш гүйцэтгүүлэх тогтоол хотын хурлаас гаргах эрхтэй баймуй

ДӨЧИН ДОЛООДУГААР ЗҮЙЛ. Хотын хурлаас зохиож эрхбиш гүйцэтгүүлэхээр гаргасан тогтоолууд нь тогтоосон хуул дүрэмд зөрчих зүйлгүй байваас зохимуй.

ДӨЧИН НАЙМДУГААР ЗҮЙЛ. Эрх биш гүйцэтгүүлэхээр гаргасан тогтоолыг хотын дотор албаны газруудад тунхаглан зарлахын дээр олон ард түмэнд таниулан зарлах явдлыг хотын захиргааны газраас эрхлэн гүйцэтгүүлэхээс гадна мөнхүү тогтоолыг устгах буюу өөрчлөх явдлыг уг харанхуйд тогтоосон ёсоор дагаж гүйцэтгэмүй.

ДӨЧИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. Хотын нэг биш гүйцэтгүүлэхээр гаргасан тогтоолыг зөрчигчдийг хууль дүрэмд тогтоосон ёсоор ял торгож шийтгэгдмүй.